

ШИНЭ БАГШИЙН ЧАДАМЖИЙГ ҮНЭЛЭХ НЭГЭН ХУВИЛБАР

С.Энхтүвшин

(МУБИС-ийн БоСС-ийн БСАЗТэнхмийн багш)

e-mail: Senkhtuv@yahoo.com

Abstract

Teacher evaluation is essential for improving teaching and learning outcomes. This paper will provide the best experiences of new teacher evaluation approaches of Singapore, Finland, USA and Korea. It will also serve as a springboard for further discussions on designing the competence based assessment framework for new teachers in Mongolian context.

Түлхүүр үг

Багшийн чадамж, гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээ, багшийн бүтээлийн сан

Багшийн үнэлгээ нь хувь багшийн ажлын гүйцэтгэл төдийгүй сургалтын чанарыг сайжруулах үйл явцад, улмаар сургуулийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулдаг. Багшийн бэлтгэгдсэн түвшин, чанар нь сургалтын үйл явц, үр дүнд шууд нөлөөлдөг. Чанар нь “шаардлагад нийцсэн байх” гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд энэ нь орцын, үйл явцын, гарцын гэсэн гурван түвшинд сайжирч болно. Энэхүү өгүүлэлд авч үзэх шинэ багшийн чадамжийн үнэлгээ нь багш бэлтгэх сургууль төгсөгчийг ерөнхий боловсролын сургууль сонгон авах, улмаар дадлагажуулан сургах орцын ба үйл явцын түвшинд төвлөрөх болно. Багшийн, ялангуяа багш бэлтгэх сургууль төгсөгч – шинэ багшийн чадамжийн үнэлгээний үр дүнтэй тогтолцоог боловсруулах нь сургалтын чанарыг сайжруулах ба багшийн мэргэжлийн чадамж, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, үнэлэх шалгуурыг оновчтой боловсруулах, ажлын байранд зөв сонгож, шалгаруулах, дадлагажуулан хөгжүүлэх, зөвлөн туслах болон мэргэшсэн үнэлээчдийг сургаж, бэлтгэх ажлыг шаардаж байна. Эл өгүүлэлд АНУ, БНСУ, Сингапур, Финлянд зэрэг орны шинэ багшийн чадамжийг үнэлж буй туршлагад хийсэн анализ, өөрийн орны нөхцөлд хэрэглэж болох нэгэн хувилбарыг боловсруулсан үр дүнг авч үзсэн болно.

1. Улс орнуудын шинэ багшийг үнэлж буй туршлагаас

Сүүлийн жилүүдэд багшлахуйн чанарыг сайжруулах асуудлаар олон улсын дээд хэмжээний уулзалт, хурлууд тогтмол зохион байгуулагдаж, харьцуулсан судалгааны үр дүн болон ололт амжилт, туршлагаа хуваалцаж байгаа нь багшийн ажлыг үнэлж дүгнэх асуудлыг нухацтай хэлэлцэх сайхан боломжийг олгож байна. 2011 оны 03-р сарын 16-17-нд АНУ-ын Нью Йорк хотноо зохион байгуулагдсан дээд хэмжээний уулзалт нь олон улсын боловсролын ерөнхий нарийн бичгийн дарга Фред ван Леювиний онцлон тэмдэглэсэнээр, “багш” мэргэжлийн асуудлаар боловсролын сайд нар, багш нарын холбооны тэргүүнүүд хамтдаа нэг ширээнд сууж, ярилцах уулзалт-хэлэлцүүлэг¹ -үүдийн эхлэлийг тавьсан билээ. Уг дээд хэмжээний уулзалт багшийг чанартай бэлтгэх, хөгжүүлэх асуудлыг нухацтай хэлэлцэхдээ дөрвөн асуудалд төвлөрч ярилцсаны нэг нь бидний онцлон авч үзэж буй **багшийн үнэлгээ**, түүний чиг хандлагад гарч буй шинэчлэл байв.

Энэ чиглэлээр Сингапур, Финлянд, Канад, Дани, АНУ зэрэг улс багшийг үнэлэх ажлын арга туршлагаа хуваалцсан юм.

Дээд хэмжээний уулзалтад оролцсон улс орнуудын үнэлгээний хандлага янз бүр байв. Тухайлбал, Сингапур улсад засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд зохион байгуулдаг гүйцэтгэлийн менежментэд тулгуурласан үнэлгээ давамгайлж байхад Финлянд мэтийн умардын орнуудад багшийн өөрийн болон мэргэжил нэгтний үнэлгээнд тулгуурласан сургууль давуу эрхтэй зохион байгуулдаг үнэлгээний тогтолцоо зонхилдог аж.

Дээрх уулзалтаас хоёр жилийн дараа “Багшлах мэргэжлийн олон улсын дээд хэмжээний уулзалт – 2013”-ыг зохион байгуулж, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагаас эрхлэн явуулсан “21-р зууны багш нар: Үнэлгээний тусламжтайгаар багшлахуйг сайжруулах нь” сэдэвт судалгааны тайланг хэлэлцсэн нь багшийн үнэлгээ нь тулгамдсан чухал асуудлын нэг болохыг харуулж байна.

¹ Vivien Stewart. Improving Teacher Quality Around the World: The International Summit on the Teaching Profession. New York. 2011. P. 12.

Эдгээр дээд хэмжээний уулзалтад багшийн үнэлгээний асуудлаар тавигдсан илтгэлүүдээс харахад багшийг үнэлэхэд **гүйцэтгэлд суурилсан үнэлгээ** давамгайлах хандлагатай болж байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь багш бэлтгэх сургууль төгсөгч – шинэ багшийг үнэлэх асуудалд ч хамаатай гэж үзэж байна. Учир нь багш бэлтгэх сургууль төгсөгч нь багш мэргэжлийн чадамжуудыг эзэмшсэн эсэхийг тогтоох баримт нотолгоог цуглуулах, түүнд тулгуурлан шийдвэр гаргах үнэлгээ нь гүйцэтгэлд тулгуурлахыг шаарддаг.

Сингапур улсын туршлага

Сингапурын үнэлгээний тогтолцоог дээд хэмжээний уулзалтад оролцогчид хамгийн үлгэр жишээ тогтолцоо гэж үнэлэхдээ түүний багшийг мэргэжил дээрээ өсч хөгжихөд дэмжлэг үзүүлдэг туршлагыг нь онцолж байв. Үүнээс харахад, багшийн үнэлгээ нь багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаатай холбогдсон нөхцөлд үнэ цэнэтэй, ач холбогдолтой болдог аж.

Сингапур улсын туршлагаас харахад, багш бэлтгэх сургууль төгсөгчийн заавал эзэмших чадамжийн хүрээнд (Graduand Teacher Competencies Framework) шинэ багш нь ямар түвшинд байгаагаа үнэлсэн өөрийн үнэлгээний тайлан бичдэг байна. Тэгэхдээ бас дараагийн жилүүдэд чухам юуг, ямар талаа хөгжүүлэхэд түлхүү анхаарч ажиллахаа онцлон дурдах ёстой аж.

Багш боловсролын хөтөлбөрийн төгсгөлд буюу багш бэлтгэх сургууль төгсөхөд **бүтээлийн сангийн үнэлгээ** хийнэ. Энэхүү бүтээлийн санд дараах зүйлийг оруулах ёстой. Үүнд:

- Судалгааны тайлангууд
- Төслүүд
- Багш бэлтгэх сургалтын явцад үндсэн чадамжуудыг хэр зэрэг өргөн хүрээтэй, гүн бат эзэмшиж, хөгжүүлж байгаад эргэцүүлэл хийхээр сонгож авсан бусад бүтээлүүд байна. Эдгээрийг дотоодын (тухайн байгууллагын) болон гадны үнэлээчид үнэлнэ.

Бүтээлийн сан бүрдүүлэх үйл явц нь:

- Цуглуулах,
- Эргэцүүлэх,
- Зохион байгуулах, цэгцлэх,
- Санал зөвлөгөө авах,
- Засан сайжруулах,
- Үнэлэх,
- Хамтарч ярилцах, хуваалцах гэсэн үйлүүдээс бүрддэг байна.

Сингапурын багш нар ажлаа жил бүр үнэлүүлнэ. Багш ажлаа үнэлүүлээд, А, В, С, D, E гэсэн дүн авна. Америкийн боловсрол судлаач Билл Жаксоны 2010 онд Сингапурт хийсэн судалгааны тайландаа тэмдэглэснээр, багш нарын 2% нь А үнэлгээ авдаг бол ихэнх багш нар С үнэлгээ авдаг байна. Цалингийн нэмэгдэл (үндсэн цалингийн 30 хувь хүртэл) нь эл үнэлгээний тогтолцоотой нягт холбоотой байдаг аж. Хэрэв багш D үнэлгээ авбал тодорхой нэмэгдэл урамшил авч чадахгүй бөгөөд энэ нь гурван жил үргэлжилнэ. Хэрэв E үнэлгээ авбал ажлаас халагдана. Ярилцлага өгсөн сургуулийн захирал эмэгтэй, “10 жил ажиллахдаа иймэрхүү багштай нэг ч удаа таарч байгаагүй бөгөөд, саналаараа ажлаасаа халагдсан чадвар муутай цөөн багшийг мэднэ”² гэжээ.

Сингапурын туршлагаас харахад, багш нарын үнэлгээ нь дараах гурван шалгуур дээр үндэслэдэг байна:

1. Гүйцэтгэл
2. Хувь нэмэр
3. Бодит чадавх

Гүйцэтгэл нь:

- Суралцагчдын шалгалтын үр дүн ба сурлагын дүн
- Багшийн хичээлд суусан албан ба албан бус ажиглалт
- Мэргэжилтнүүд, сургуулийн удирдалага, тэнхим болон заах аргын нэгдлийн ахлагч, эцэг эх, сурагчдаас авсан санал шүүмж (feedback)

Оролцоо нь:

- Сургуулийнхаа төлөө хийж байгаа нэмэлт зүйлүүдээс бүрдэнэ. Тухайлбал,
 - Уулзалтад оролцох
 - Ажлын хэсэгт ажиллах

² Bill Jackson. The Professional Lives of Teachers. August 2010 in Singapore.

- Хичээлээс гадуурхи үйл ажиллагаа явуулах
- Сонгон, дугуйлан хичээллүүлэх, клуб ажиллуулах

Бодит чадавх нь:

- Мэргэжлийн онолын мэдлэг, бэлтгэлдээ тулгуурлаад гүйцэтгэл, хувь нэмрээ нэмэгдүүлэх чадавхтай эсэх

АНУ-ын туршлага

АНУ-д үнэлгээний тогтолцоог сайжруулах шүүмжлэл өрнөж, үнэлгээнд үйл ажиллагааны эргэх холбоо үгүйлэгдэж байгааг цохон тэмдэглэж байв. 2011 онд Америкийн Багш нарын холбооны боловсруулсан туршилтын үнэлгээний тогтолцоог 100 гаруй дүүрэгт туршиж, үр дүнг хэлэлцжээ. Америкийн багш нарын холбооноос боловсруулж, туршиж буй уг үнэлгээ нь багшлахуйн чанарыг хэмжих маш нарийн стандартад үндэслэсэн бөгөөд багшийн хөгжил ба үнэлгээг уялдуулж өгснөөрөө онцлог аж.

АНУ-ын хувьд багшлах эрхийн стандарт нь **багшийн гүйцэтгэлд** тулгуурласан бөгөөд багш юу мэдэх ёстой, багш ямар байх, бас юу хийж чаддаг байхыг ямар курс хичээлүүд судалсан байх шаардлагатай гэдгээс илүү өргөн хүрээнд тодорхойлсон байна. Чадамжийг тодорхойлох шалгуурыг тодорхой болгох зорилготой энэ хандлага нь багш бэлтгэх сургууль төгсөгч хэдэн цагийн хичээл үзсэн гэхээсээ илүүтэй тэдний чадварыг хөгжүүлэхэд онцгой анхаарснаараа онцлог юм.

Багшлах эрхийн үнэмлэхээ авахын тулд багш бэлтгэх сургууль төгсөгч (teacher candidate) буюу шинэ багш нь дараах гурван хэсгээс бүрдэх чадварын шалгалтыг өгч, үнэлгээг хийлгэсэн байх шаардлагатай. Үүнд:

Praxis³ – I буюу Академик чадварын шалгалт

Хэддүгээр ангид, ямар хичээл заахаас үл хамааран бүх багшид хэрэгтэй унших, бичих болон математик чадварыг үнэлэх шалгалтыг багш бэлтгэх сургуульд суралцаж байх хугацаандаа өгсөн байх ёстой. Энэхүү шалгалтыг уламжлалт (цаас, харандаатай) хэлбэрээр болон компьютерийн программын тусламжтай авдаг аж. Шалгалтын агуулга⁴ нь:

- Асуудлын мөн чанар, учир шалтгааныг ухамсарлан ойлгож унших чадварыг сорих 46 асуулт бүхий даалгаврыг 75 минут гүйцэтгэнэ.
- Бүтээлчээр сэтгэн бодож, дүгнэлт гарган бичих чадварыг сорих 44 асуулт бүхий даалгаврыг 38 минутанд гүйцэтгэж, 30 минутанд эсээ бичнэ. Нийтдээ 68 минутанд гүйцэтгэнэ.

Тоон ба хэмжихүйн ухааны мэдлэгээ ашиглан хүрээлэн буй орчин, нийгэм соёлдоо гарч буй ямар нэг өөрчлөлтийн мөн чанар, зүй тогтлыг ухаарч ойлгох, өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэглэгдэх нарийн тооцоо хийж чадах эсэхийг сорих 46 асуулт бүхий даалгаврыг 75 минутанд гүйцэтгэнэ.

Praxis – II

Багш боловсролын болон заах хичээлийн мэдлэгийн шалгалтыг багш бэлтгэх сургуулийг төгссөний дараа өгнө.

- Заах хичээлийн онолын мэдлэгийн шалгалт
- Сурган хүмүүжүүлэх ухаан, боловсролын сэтгэл судлалын мэдлэг, чадварын шалгалт
- Мэргэжлийн дидактик (content pedagogy)-ийн мэдлэг чадварын шалгалт

Дээрх гурван хүрээнд олон хариултаас зөвийг сонгох тест бөглөн, бүлэг бүрийн төгсгөлд гурваас дөрвөн кейсийг шинжилж, кейс бүр дээр гурван богино асуултанд хариулт бичих даалгаврыг 120 минутанд гүйцэтгэнэ.

Praxis – III

Багшлахуйн (анги танхим дахь үйл ажиллагааны) гүйцэтгэлийн үнэлгээ.

Энэхүү үнэлгээг сургуульд нэг жил багшилсны дараа хийх боловч багшилж байх үйл явцад ажигласан баримт материалыг нотолгоо болгон ашиглана.

³ Багшлах чадварын шалгалт

⁴ Fritz Stewart, Rick Sliter. Cracking the Praxis 2nd Edition. New York. 2012. p. 6, 28, 58.

Шинэ багш нь ажиллаж буй сургууль дээрээ **бүтээлийн сан** хийсэн байна. Түүнд: сурагчийн ажлын дээж, танхим дахь хичээлийн видео бичлэг, эдгээр бүтээгдэхүүнд тулгуурлан бичсэн дүн шинжилгээ/анализ, эргэцүүлэл орно. Бүтээлийн сан нь шинэ багш нарт практик үйл ажиллагаагаа тэдний сурагчдын бодит хэрэгцээ, сургуулийн нөхцөл байдалтай холбон харуулах боломжийг олгодог байна.

Praxis – 3 нь шинэ багшийн багшлах чадварыг үнэлэхэд чиглэх бөгөөд дараах зүйлд төвлөрнө:

- Сургалтын төлөвлөлт (сургалтын хөтөлбөр боловсруулах, ээлжит хичээлийн төлөвлөлт г.м)
- Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт
- Анги танхимын менежмент
- Сурагчийн ахиц дэвшлийн үнэлгээ
- Сургалтын үр дүн

Үүнээс гадна, багш суралцагчийн хөгжлийн түвшин ба соёлын ялгаатай байдалд хэр мэдрэмжтэй хандаж байгааг үнэлнэ.

Анги танхимд хийх ажиглалт, уг ажиглалтын өмнө ба дараа үндэсний болон орон нутгийн түвшинд бэлтгэгдсэн мэргэжилтэн, судлаачтай хийх ярилцлага нь Praxis-III-ийн үндсэн хэсэг аж.

Ажиглалтын материалд (ажиглалтын тэмдэглэл, үнэлгээний хуудас) ээлжит хичээлийн төлөвлөгөө гэх мэтийн ажлын дээжээс нэмж хавсаргана.

Үнэлгээ амжилттай болсон тохиолдолд муж улсын боловсролын байгууллагаас багшлах эрхийн лиценз олгох шийдвэр гарна.

Шинэ багшийн чадамжийг үнэлэх гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээнд бүтээлийн санг ашиглах санаачлагыг хөхүүлэн дэмжиж буй нийтлэг дүр зураг ажиглагдаж байна. Судлаач Нона Лионы үзсэнээр, бүтээлийн сан нь багшлахуйн чанарт эергээр нөлөөлөх шинэ профессионализмын үр үндэс болж байгаа юм. Тухайлбал:

Бүтээлийн сангийн үнэлгээний тогтолцоо нь стандартыг нарийн нягт, үлгэр жишээ сайн байхыг шаардаж; үр дүнтэй суралцахуйг баримтжуулж, багшлахуйд өөрийгөө бэлтгэсэн, бас тасралтгүй суралцаж байгаа гэдгээ харуулж; хамтран багшилж, бүтээлчээр хамтран ажиллаж, практик үйл ажиллагаагаа шүүмжлэлтэйгээр шинжилж чадах суралцагч-багш нарын хамт олныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахыг шаардаж байна⁵.

Гэхдээ энэ сайхан тэмүүлэл тийм амар буй болохгүй. Үндэсний зөвлөлийн үнэлгээнд хэрэглэх бүтээлийн сангийн дизайныг анхлан боловсруулагч Лий Шуманы цохон тэмдэглэснээр, дээрх гайхалтай боломжууд нь багагүй эрсдэлийг бас дагуулдаг байна. Тухайлбал, юу чухал вэ гэхээсээ юуг хялбархан харуулж болох уу гэдгийг чухалчлах, багшлах ажлын мөн чанараасаа хазайх, хөзрийн цуглуулгын шоу шиг зүйл болж ч болзошгүй⁶ аж.

Гэвч олон багш өөрийн үнэлгээний тайландаа бүтээлийн сангийн үнэлгээний ач холбогдлыг дурдсан байв. Залуу багш Дэвид Хэйнес (David Haynes) бичихдээ:

Багшлах эрхийн үнэмлэхийн үнэлгээнд зориулж хийсэн бүтээлийн сан маань их энгийн, тэгсэн мөртөө миний карьер, мэргэжлийн туршлагыг харуулах хамгийн сайн бүтээгдэхүүн болсон. Үүнээс өмнө, би хүүхдүүдтэйгээ юу хийх вэ, яагаад би үүнийг хийж байгаа вэ гэдгийг ингэж ултай бодож байснаа санахгүй байна. Би практик үйл ажиллагаагаа шүүмжлэлтэйгээр харж, түүнийг нарийн, өндөр түвшний стандарттай жишиж үнэлсэн юм. Өдөр тутмын ажилдаа өөрийнхөө тавьсан зорилгын талаар дахин бодож, хичээлээ засан сайжруулж, шинэ чиглэлд давшиж байв. Би үнэлгээ хийхийн өмнөх үед байснаасаа их л өөр багш болсон доо гэж боддог⁷.

Үндэсний зөвлөлийн багшийн үнэлгээний ажлын чиг баримжааг тогтооход багагүй үүрэг гүйцэтгэсэн Стэнфордын их сургуулийн Багшийн үнэлгээний төслийн бүтээлийн санг анхлан туршихад оролцсон багш нарын 89% нь **бүтээлийн сан бүрдүүлэх үйл явц нь тэдний багшлахуйд зарим эерэг үр дүнг авчирсан** гэж хэлсэн байдаг. Багшийн практик үйл ажиллагааг тодорхой стандартыг хангахыг шаардаж, эерэг түлхэц үзүүлжээ. Ингэснээр багшлах явцдаа төдий л ач холбогдол өгдөггүй байсан зүйлүүдийг шинэ багш нар анхааралтай авч үзэх болсон байна. Бүр 2001 онд явуулсан судалгаагаар, 5600 шинэ багшийн 92 хувь нь үндэсний зөвлөлийн

⁵ Lyons, N.P. (2008) Portfolio possibilities: Validating a new teacher professionalism. Pp. 247-264. New York: Teachers College Press.

⁶ Shulman, L. (1998) Teacher portfolios: A theoretical activity. Pp. 23-37. New York: Teachers College Press.

⁷ Haynes, D.D. (2010). One teacher's experience with National Board assessment. Educational Leadership. 52(8). p. 60.

хийсэн энэхүү үнэлгээ нь “намайг илүү сайн багш болох”-д нөлөөлсөн гэж үзсэн бол 80% нь маш сайн сургалтын хөтөлбөр боловсруулах, сурагчийг үнэлэх чадвараа сайжруулахад, эцэг эх, бусад багш нартай харилцаа тогтоох, хамтарч ажиллахад нь тус болсон гэж үзэж байсныг Стэнфордын их сургуулийн профессор Линда Дарлинг Хаммонд илтгэлдээ дурдсан байдаг⁸.

Үндэсний зөвлөлөөс багшийн бүтээлийн сангийн талаар явуулсан судалгаанаас, багш нарын багшлахуйн чадварт бүтээлийн сан бүрдүүлэхийн өмнө ба дараа дараах гүйцэтгэлүүдээр илэрхий ахиц гарсан нь илэрсэн байна:

- Сургалтыг төлөвлөх
- Сургалтыг дизайнчлах
- Сургалтыг хөтлөн явуулах
- Анги танхим дахь үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах
- Суралцагчдын суралцах үйл явцыг үнэлэх
- Мэргэжлийн онолын мэдлэгээ ашиглах
- Мэргэжил дээрээ хамтран суралцах, хөгжих үйл ажиллагаанд оролцох⁹.

Багш нар хичээл заасан видео бичлэг, сурагчдынхаа ажилд хийсэн анализ зэрэг нь тэднийг сургалтыг хэрхэн зохион байгуулах, даалгаврыг хэрхэн өгөх, сурагчдын суралцах үйл явцад хэрхэн дүн шинжилгээ хийх, шаардлагагай үед багш хэрхэн дэмжлэг үзүүлэх, курс хичээлд өөрчлөлт оруулах зэргийг илүү сайн ойлгоход нөлөөлсөн гэж онцлон тэмдэглэжээ.

Калифорн, Орегон мужийн туршлагаас харахад, шинэ багшийн гүйцэтгэлийн үнэлгээ нь багш боловсролын хөтөлбөрт, бас багшийн ажлын байранд дадлагажих үед ч хэрэглэгддэг байна. Иймэрхүү үнэлгээ нь багшаас дараах зүйлийг баримтжуулахыг шаардана:

- Нэгж хичээлийн төлөвлөгөө
- Нэгж хичээлийг заасан үйл явц
- Хичээлүүдийн видео бичлэг ба шүүмж
- Сурагчдын хэр суралцаж буйг харуулсан цуглуулга, түүний үнэлгээ

2010 оны байдлаар бага сургуулийн багш нарын 80%, дунд сургуулийн багш нарын 80 шахам хувь нь иймэрхүү үнэлгээнд хамрагдсан байна. Үнэлгээнд хамрагдсан нэгэн шинэ багш хэлэхдээ, энэ үйл явц нь багшаас нэгж хичээлийг төлөвлөх ба заах, өдөр тутмынхаа хичээлд сурагч бүрийн хэрэгцээг хангаж байна уу гэдэг үүднээс эргэцүүлэл хийх, дараагийн өдрийн хичээлийг төлөвлөхдөө юуг өөрчлөхийг ёстойг бодохыг шаарддаг гэжээ. Тэрээр цааш нь: “Хэдийгээр би өмнө ямар нэг хэмжээнд эргэцүүлэл хийдэг байсан ч энэ удаагийнх бол их өөр. Би эргэцүүллийг өөрөөр хийсэн гэж хэлмээр байна. Хичээл дээр юу болсон тухай зүгээр тоочих бус, багшлах үйл ажиллагаанд, бас төлөвлөлтөд үр өгөөжтэй болж байв. Ер нь сайн багш болоход чухал үүрэг гүйцэтгэсэн” гэжээ.

Энэ төрлийн үнэлгээ нь шинэ багш нараас дараах зүйлийг шаарддаг байна:

- Муж улсын тухайн боловсролын стандартад үндэслэн долоо хоногийн хичээлийг төлөвлөж, заах
- Өөрсдийн заасан хичээлдээ эргэцүүлэл хийх
- Үүнд үндэслэн, дараагийн өдрийнхөө төлөвлөлтөд өөрчлөлт оруулах, залруулга хийх
- Өөрсдийн заасан хичээлийн видео бичлэгт анализ хийх, санал шүүмж өгөх
- Сурагчдын суралцах үйл явцыг харуулсан баримт цуглуулах, дүн шинжилгээ хийх
- Юу сайн болж байгаа, юу болохгүй байгаа, түүний учир шалтгааныг эргэцүүлэх
- Дараа хичээл заахдаа юуг өөрөөр хийхээ төлөвлөх

Шинэ багш нь сурагчийн өмнөх мэдлэг, туршлагыг хэрхэн тооцохоо хичээлийн төлөвлөлтдөө заавал тусгаж харуулсан байна. Тусгай хэрэгцээт сурагчтай яаж ажиллах асуудал ч мөн тусгагдана. Сурагчийн амжилтад хийсэн шинжилгээ нь багшийн үнэлгээний нэгэн чухал хэсэг болдог аж.

БНСУ-ын туршлага

Багш бэлтгэх сургууль төгсөгч нь орон нутгийн боловсролын төв (16 төв байгаа)-д бүртгүүлж, багшаар ажиллахыг хүссэн өргөдөл өгнө. Үүний дараа багш сонгон шалгаруулах шалгалт өгнө. Энэхүү шалгалт нь дараах үе шаттай явагддаг байна:

Нэгдүгээр шат: Суралцахуй, багшлахуй, боловсролын эрх зүйн мэдлэгийг шалгах сорил өгнө.

⁸ Linda Darling-Hammond. (2009). *Teacher Preparation and Teacher Learning*. p. 623.

⁹ Tracz et al. (2005). *Improvement in teaching skills: Perspectives from National Board for Professional Teaching Standards field test network candidates*. San Francisco.

Хоёрдугаар шат: Багшийн ёс зүй, үнэт зүйл, хандлагыг үнэлэх бичгийн шалгалт өгч, эсээ бичнэ.

Гуравдугаар шат: Гүнзгийрүүлсэн ярилцлага ба ур чадварын шалгалт өгнө. Үүнд:

- Хичээл зааж үзүүлэх
- Ярилцлага өгөх

2011 оны байдлаар 58706 шинэ төгсөгч өргөдөл өгсөнөөс 2525 багш дунд сургуульд ажиллах эрхээ авсан байв.

2. Шинэ багшийн чадамжийг үнэлэх хувилбар

Үе шат	Чадамжийг үнэлэх даалгаврын төрөл хэлбэр	Агуулга	Хэзээ үнэлэх вэ?
I	<p><i>Багш мэргэжлийн мэдлэг, чадварыг үнэлэх даалгавар</i></p> <ul style="list-style-type: none"> ▪ Стандартчилсан тест ▪ Бичих даалгавар <ul style="list-style-type: none"> ○ 100-150 үгтэй товчхон хариулт ○ 300-600 үгтэй дэлгэрэнгүй хариулт 	<ol style="list-style-type: none"> 1. <i>Заах хичээлийн онолын мэдлэгийг шалгах тест (25-30 даалгаварыг 60 минутанд гүйцэтгэнэ)</i> 2. <i>A/ СХУ, боловсролын сэтгэл судлалын мэдлэг шалгах тест</i> <ul style="list-style-type: none"> ▪ Суралцагчийн хөгжил ба суралцахуй (25%) ▪ Багш, багшийн үйл ажиллагаа ба хөгжил (25%) ▪ Сургалт, үнэлгээ, суралцах орчин (30%) ▪ Сургууль, боловсролын бодлого, эрх зүй (20%) <p><i>Б/ Багшийн асуудал шийдвэрлэх чадварыг үнэлэх асуулт даалгавар</i></p> <ul style="list-style-type: none"> ▪ Өгөгдсөн кейст анализ хийнэ. ▪ Өгсөн асуултуудад товч (асуулт бүрд 100-150 үгэнд) хариулна. <p><i>В/ Багшийн үнэт зүйл, итгэл үнэмшил, эерэг хандлагыг үнэлэх асуулт даалгавар</i></p> <ul style="list-style-type: none"> ▪ Асуулт даалгаврын тавил буюу нөхцөлд анализ хийнэ. ▪ Өөрийн байр суурийг илэрхийлсэн дэлгэрэнгүй (300-600 үгтэй) хариулт бичнэ. <ol style="list-style-type: none"> 3. <i>Мэргэжлийн дидактикийн мэдлэг, чадвар шалгах тест (25-30 даалгаварыг 60 минутанд, заах аргазүйн шийдэл гаргах кейст шинжилгээ хийх даалгаврыг 30 минутанд гүйцэтгэнэ)</i> 	<p>Багш бэлтгэх сургууль төгссөний дараа</p>
<p>Нэг дэх шатны шалгалтыг амжилттай өгсөн тохиолдолд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт дадлагажигч багшаар ажиллах эрх нээгдэнэ. Уг эрхийг шалгалтын комиссын үнэлгээний дүнд тулгуурлан аймаг, дүүргийн боловсролын газраас олгоно. Сургуулийн захиргаа ажилд сонгон шалгаруулж авч буй шинэ багштай ярилцлага хийж, хичээл заалгаж үзэж болно. Ярилцлага болон хичээлийн ажиглалтад тулгуурлан тухайн дадлагажигч багшид мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллах зөвлөх багшийг томилж ажиллуулна. Зөвлөх багшаар ажиллуулах тухай захирлын тушаал гаргана. Дадлагажигч багш өөрийгөө хөгжүүлэх хувийн ажлын төлөвлөгөө гарган ажиллана.</p>			
II	<p>Багшлахуйн гүйцэтгэлийн үнэлгээ.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Багшийн өөрийн 	<ul style="list-style-type: none"> ▪ Шинэ багшийн багшлах чадварыг үнэлэхдээ дараах баримтыг ашиглана: <ul style="list-style-type: none"> ○ Нэгж хичээлийн хөтөлбөр, ээлжит хичээлийн төлөвлөгөө, 	<p>Дадлагажигч багшаар нэг жил ажилласны</p>

	<p>үнэлгээний тайлан</p> <ul style="list-style-type: none"> ▪ Анги танхимд хийх ажиглалт ▪ Ярилцлага ▪ Багшийн бүтээлийн сан 	<p>тэдгээрт хийсэн эргэцүүлэл (эдгээрийг багшийн бүтээлийн санд хийсэн байна)</p> <ul style="list-style-type: none"> ○ Анги, сурагчдын хамт олон, эцэг эхтэй ажиллах төлөвлөгөө, төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт ○ Сурагчдын суралцах-танин мэдэх үйл ажиллагааг хөтлөх, чиглүүлэх, зохион байгуулах чадвар ○ Сурагчийн ахиц дэвшлийг үнэлж, дүн шинжилгээ хийсэн байдал ○ Сургалтын болон хичээлээс гадуурх ажлын үр дүн, оролцогчдын сэтгэл ханамж ○ Багш, хүүхэд бүрийн хөгжлийн түвшин ба ялгаатай байдлыг мэдрэх, ойлгох чадвар <ul style="list-style-type: none"> ▪ Багшийн өөрийгөө хөгжүүлсэн, мэргэжлийн хамт олон, эцэг эхтэй хамтарч ажилласан байдлыг үнэлэхдээ тухайн багштай болон сургуулийн удирдлага, заах аргын нэгдлийн ахлагч, зөвлөх багшаар ажилласан багштай хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагын материалыг баримт болгон ашиглана. 	<p>дараа гүйцэтгэлийн үнэлгээг хийнэ. Амжилттай дүн үзүүлсэн тохиолдолд багшлах эрхийн үнэмлэхийг олгоно.</p>
--	---	--	---

Дүгнэлт, санал

- АНУ, Сингапур зэрэг орны туршлагаас харахад, шинэ багшийн чадамжийн үнэлгээ нь багш бэлтгэх сургалтын чанарыг сайжруулах нэгэн хэрэглүүр болж байна.
- Багшлахуйн гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээ нь багшийг, ялангуяа шинэ багшийг үнэлэх чиг хандлага болж байна.
- Сингапурын гүйцэтгэлийн менежментэд тулгуурласан үнэлгээ, Финляндын багш нарын өөрийн үнэлгээ болон мэргэжил нэгтний үнэлгээ нь багшийн үнэлгээний олон улсын чиг хандлагыг тодорхойлоход үнэтэй хувь нэмэр оруулж байна.
- АНУ-ын багшлах чадварын шалгалт буюу Praxis – I, II болон багшлахуйн гүйцэтгэлийн үнэлгээ болох Praxis – III-ийг шинэ багшийн чадамжийг үнэлэх даалгаврыг бэлтгэхэд загвар болгон ашиглаж болох юм.
- Багш бэлтгэх сургуулийн оюутны явцын үнэлгээнд тэдний бүтээлийн санг ашиглаж, улмаар багшийн бүтээлийн сан бүрдүүлэх, хамгаалах бэлтгэлтэй болоход нь зөвлөн туслах нь шаардлага байна.
- Багш боловсролын хөтөлбөрийн багц материал боловсруулах төслийн хүрээнд оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх даалгаврын сан бүрдүүлж, үр дүнг туршин шалгах ажилд дэмжлэг үзүүлэх нь хэрэгтэй байна.

Ном зүй

1. Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам. БШУ-ны сайдын 2013 оны А/305 тоот тушаал.
2. Bill Jackson. The Professional Lives of Teachers. August 2010 in Singapore.
3. ЕБС-ийн багшийн ажлыг үнэлж, дүгнэх журам. БШУ-ны сайдын 2013 оны 293-р тушаал.
4. Fritz Stewart, Rick Sliter. Cracking the Praxis 2nd Edition. New York. 2012.

5. Haynes, D.D. (2010). One teacher's experience with National Board assessment. *Educational Leadership*. 52(8).
6. Linda Darling-Hammond.(2009). *Teacher Preparation and Teacher Learning*.
7. Lyons, N.P. (2008) *Portfolio possibilities: Validating a new teacher professionalism*. New York: Teachers College Press.
8. Shulman, L. (1998) *Teacher portfolios: A theoretical activity*. New York: Teachers College Press.
9. Tracz et al. (2005). *Improvement in teaching skills: Perspectives from National Board for Professional Teaching Standards field test network candidates*. San Francisco.
10. Vivien Stewart. *Improving Teacher Quality Around the World: The International Summit on the Teaching Profession*. New York. 2011.